



ДУНДГОВЬ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/01

Мандалговь

Хөдөлмөрийн дотоод журмыг
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, 122.2 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 07 дугаарын 24-ний өдрийн 06 дугаар тогтоолын 6 дугаар заалт, Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн А/560 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсугай.

2. Хөдөлмөрийн дотоод журмыг нийт албан хаагчдад танилцуулж, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ахлах мэргэжилтэнд, журамд тусгагдсан хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэх зардлыг жил бүрийн төсөвт тусган ажиллахыг ерөнхий нягтлан бодогчид тус тус даалгасугай.

3. Хөдөлмөрийн дотоод журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын 2023 оны А/18 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Н.ГАНТУЛГА

